



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/65

Хархорин сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвд дэлгэц (Соёлын үйлчилгээг сайжруулах) нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Нямдаваа (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Н.Мяасүрэн (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, дүгнэлт гарган танилцуулахыг Үнэлгээний хороо (Н.Нямдаваа)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Очир-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

